

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2022

Бид харилцагч төвтэй,  
мэргэшсэн, ёс зүйтэй даатгалын  
үйлчилгээг шилдэг шийдлээр  
хүртээмжтэй хүргэж итгэлтэй  
ирээдүйг бүтээлцэнэ.



## АЛСЫН ХАРАА

Даатгалын иж бүрэн үйлчилгээг айл өрх, албан байгуулага бүрт хүргэсэн дэлхийн жишиг компани байна.



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагч төвтэй, мэргэшсэн, ёс зүйтэй даатгалын үйлчилгээг шилдэг шийдлээр хүртээмжтэй хүргэж итгэлтэй ирээдүйг бүтээлцэнэ.



## ҮНЭТ ЗҮЙЛС

- Харилцагчийн сэтгэл ханамж
- Мэргэжлийн өндөр ур чадвар
- Шинийг санаачлах
- Нийгмийн хариуцлага

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эх орныхоо тайван амгалан, иргэдийнхээ тав тухтай амьдрал, Монгол Улсынхаа хөгжлийн төлөө өдөр бүр зогсолтгүй ажиллаж байгаа эрхэм хэрэглэгч Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе!

Монголын даатгалын салбарын үүсэл хөгжлийг эхлүүлсэн анхдагч компани “Монгол Даатгал” ХК-ийн хувьд өөрийн өргөн мэдээллийн бааз суурь, тогтвортой соёл, мэргэшсэн чадварлаг баг хамт олонд тулгуурлан Монгол улсын 21 аймаг дахь өөрийн салбар, даатгалын борлуулалтын хамгийн өргөн сүлжээ бүхий 600 төлөөлөгчөөрөө дамжуулан харилцагч төвтэй даатгалын үйлчилгээг санал болгон, цахимаар даатгалын үйлчилгээг хүргэн, тэдний хүсэл, хэрэгцээ, сэтгэл ханамжийг 7/24 цагаар зогсолтгүй сонсож судлан, байнгын сайжруулалтыг хийж, 2022 оны байдлаар бидэнд итгэл хүлээлгэсэн даатгуулагчдын тоо 200 гаруй мянгад хүрч, жилээс жилд нэмэгдэн, санхүүгийн голлох үзүүлэлтээр тэргүүлж байна. Бид хөгжлөөрөө ямагт анхдагч, тэргүүлэгч байгааг хэлэхэд таатай байна.

Түүнчлэн бид дэлхийд нэр хүндтэй, өндөр зэрэглэлтэй, тэргүүлэгч давхар даатгалын компаниудад эрсдэлээ шилжүүлснээр харилцагчиддаа давхар даатгагдсан хамгийн өндөр багцыг санал болгох боломжийг бүрдүүллээ.

Харилцагчидтайгаа хамтдаа хөгжүүлж буй бидний бизнес өдрөөс өдөрт өргөжин тэлж байгаа нь иргэд, байгууллагуудын даатгалын мөн чанар, ач холбогдлыг ойлгох ухамсар нэмэгдсэнтэй холбоотой. Гэсэн хэдий ч хүмүүний итгэлтэй ирээдүй, амар тайван амьдралын төлөө бидний итгэл үнэмшил цуцашгүй байж, даатгалын үйлчилгээг хялбар, ойлгомжтой, хүртээмжтэй хүргэхэд тэмүүлсээр байх болно.

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Сайн засаглалын олон улсын шалгарсан практикуудыг нутагшуулж, засаглал, менежментийн эрүүл зөв тогтолцоог хэрэгжүүлэх нь Монгол Даатгал ХК-ын эрхэм зорилгын чиглүүлэгч.

Сайн засаглалыг хэрэгжүүлснээр компанийн үйл ажиллагаа тогтвортой явагдах, бие даасан хараат бус, чанартай шийдвэр гаргалтуудыг хийх боломжийг бүрдүүлэхээс гадна цаашдын тасралтгүй өсөлт хөгжилтөд эерэгээр нөлөөлдөг.



Монгол Улсын тэргүүлэгч даатгалын компанийн хувьд бид компанийн засаглалын туршлагыг сайжруулж, эрүүл зөв тогтолцоог бий болгохын тулд компанийн засаглалын өнөөгийн түвшин, шаардлагатай өөрчлөлтүүдийг тодорхойлж, компанийн засаглалын бодлого журмыг боловсронгуй болгохоор ажиллаж байна.

№	Нэр	Эзэмшиж буй хувьцааны хувь	Бусад компанийн хувьцааг эзэмшиж буй байдал	Түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд
1	Миллиуним секюрититез менежмент ХХК	99.79 %	Байхгүй	Байхгүй
2	Бусад	0.21%		

## ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь нийт есөн гишүүнтэй бөгөөд гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгон томилдог.



**ТУЗ-ийн дарга: ГРОМОВ С.Б.**

Громов Сергей Борисович нь 2001 оноос хойш банк санхүү, даатгалын салбарт ажилласан туршлагатай. Өнгөрсөн хугацаанд "Чингис Хаан" банкны ТУЗ-ийн даргаар 2001-2016 он хүртэл, "Монгол Даатгал" ХК-д ТУЗ-ийн даргаар 2004 оноос одоог хүртэл ажиллаж байна.



**ТУЗ-ийн хараат бус гишүүн: О.ЦОГТ**

Очиржанцангийн Цогт нь Инженер эдийн засагч, татвар санхүүгийн чиглэлээр ОХУ, Япон улсад суралцсан бөгөөд Хүлэг консалтинг ТМЗ ХХК-д татварын зөвлөх, "Монгол Даатгал" ХК-д ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргаар ажиллаж байна.



**ТУЗ-ийн хараат бус гишүүн: Б.АЮУШ**

Базарын Аюуш нь Нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, эрхзүйч, эдийн засгийн ухааны доктор зэрэгтэй. Мандах дээд сургуульд зөвлөх профессор, "Райнос ассет менежмент" компанид ахлах аудитор ажиллаж байгаа бөгөөд "Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны даргаар ажиллаж байна.



**ТУЗ-ийн хараат бус гишүүн: Б.ЭНХТУЯА**

Бавуудоржийн Энхтуяа нь эдийн засагч мэргэжилтэй, бизнесийн удирдлагын магистр, удирдахуйн ухааны доктор зэрэгтэй. ШУТИС-д тэргүүлэх профессор, салбарын эрхлэгчээр ажиллаж байгаа бөгөөд "Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны даргаар томилогдон ажиллаж байна.



**ТУЗ-ийн гишүүн: С.ТЭНГИС**

Сүхээгийн Тэнгис нь Программ хангамжийн инженер мэргэжилтэй, 2014 оноос удирдах албан тушаалд ажилласан бөгөөд "Супреим Сольюшн" ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Засгийн газар, Оксфордын их сургуулийн хамтарсан судалгааны төсөлд Төслийн менежер, Цахим хөгжлийн үндэсний хороонд Ажлын албаны даргаар тус тус ажиллаж байсан туршлагатай.



**ТУЗ-ийн гишүүн: ОГАЙ Н.Ю**

Огай Наталья Юрьевна хэлзүйч, санхүүч мэргэжилтэй. ОХУ болоон Монгол улсад банк, санхүү даатгалын чиглэлээр 2003 оноос хойш ажиллаж байгаа туршлагатай. "Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр 2016 оноос одоог хүртэл ажиллаж байна.



**ТУЗ-ийн гишүүн: ТАНЯ ЛИЗУНОВА**

Таня Лизунова нь МУИС-д санхүү эдийн засгийн чиглэлээр суралцсан. 2006 оноос хойш "Чингис Хаан" банкны ТУЗ-ийн туслахаар ажиллаж байсан бөгөөд 2016 оноос хойш "Монгол Даатгал" ХК-д ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.



**ТУЗ-ийн гишүүн: ГРОМОВ Б.С.**


Громов Борис Сергеевич нь Санхүүч мэргэжилтэй, CFA институтийн гишүүн, CFA зэрэгтэй, 2016 оноос удирдах албан тушаалд ажилласан бөгөөд Galyandar ХХК-ийн Захирал, Аya enterprises ХХК-д Захирлаар тус тус ажиллаж байгаа туршлагатай.



**ТУЗ-ийн гишүүн: О.ЭРДЭНЭБУЛГАН**

Очирбатын Эрдэнэбулган нь Санхүүгийн менежмент, Төрийн захиргааны менежментээр суралцсан магистр зэрэгтэй, санхүүч мэргэжилтэй. 2003 оноос хойш удирдах албан тушаалд ажилласан туршлагатай бөгөөд одоо "Монгол Даатгал" ХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

# КОМПАНИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ 2022







Монгол Даатгал ХК нь 1934 онд “Улсыг аюулаас хамгаалах газар” хэмээн Сангийн Яамны салбар нэгж болон тулгийн чулуугаа тавьж үйл ажиллагаагаа эхлүүлсэн түүхтэй. Эдүгээ нэгэн наяны турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж, гадаад дотоодын түнш байгууллага, ард иргэддээ даатгалын үйлчилгээг тасралтгүй хөгжүүлэн хүргэж байгаа билээ.

## 2022

Байгууллагын 90 жилийн ойг угтан цахим шилжилтийн суурийг тавьсан.

## 2021

Гэгээ Эрүүл мэндийн даатгалын брэндийг бүтээлээ.

## 2020

“Монгол Даатгал” компани нээлттэй хувьцаат компани боллоо.

## 2019

Үйлчилгээний бодлогоо орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн шинэчилж логогоо ЭНГИЙН, ХЯЛБАР, УХААЛАГ шийдлийг тусгалаа.

Харилцагчдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн салбартаа анхлан ЦАХИМ ДААТГАЛЫН үйлчилгээг нэвтрүүлээ.

## 2018

“Буухиа хүү” мобайл аппликейшныг даатгалын салбарт анхлан гаргав.

ISO 9001:2015 ЧУТ-ны батламжаа хоёр дахь удаагаа баталгаажууллаа.

## 2006

Монголд анх удаа 7/24 шуурхай дуудлагын албатай болов.

## 2010

**hannover re**  
Олон улсын давхар даатгалын зах зээлийн томоохон давхар даатгагч болох “HANNOVER RE” компанитай хамтран ажиллаж эхэллээ.

## 2011

Даатгалын салбарт анх удаа өндөр хамгаалалттай олон улсын эрүүл мэндийн даатгалыг нэвтрүүлэв.

## 2012

Банкашурансыг Монголд хөгжүүлэхээр дотоодын арилжааны банкнуудтай хамтран ажиллаж эхлэв.

## 2014

Global Banking and Finance Review байгууллагаас Монгол улсын шилдэг Даатгалын компани -аар шалгаруулав.

## 2016

Даатгалын салбарт анх удаа ISO 9001:2015 ЧУТ-г хэрэгжүүлж эхэллээ.

## 2017

Утсан даатгалын үйлчилгээг анхлан нэвтрүүлэв.  
Allianz world wide care компанитай хамтын ажиллагааг эхлүүлэв.

## 2017

ISO 9001:2015 ЧУТ-ны баталгаажуулалтын гэрчилгээг гардан авлаа.

## 2005

Дэлхийн банкны төслийн хүрээнд “Малын индексжүүлсэн даатгал” -ын борлуулагчаар ажиллаж эхлэв.

## 2003

Монгол Даатгал ХК хувьчлагдав.

## 1994

Монгол Даатгал ХК-ийн ажилтнууд оролцон боловсруулсан Даатгалын тухай Монгол улсын хууль хэлэлцэгдэн батлагдав.

## 1990

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрт шилжив.

## 1974

ОУ-ын болон гадаадын байгууллагын барилга байгууламж, тээврийн хэрэгслийн заавал даатгалыг хийж эхэллээ.

## 1964

“Нэгдэл хоршооллын мал сүрэг, САА-н таримал ургамлын заавал даатгал”-ыг анхлан хийв. ОУ-ын брокер болон давхар даатгагч нартай хамтран ажиллаж эхэллээ.

## 1962

Улсыг аюулаас хамгаалах газар нь Улсын даатгах газар нэртэй болж өөрчлөгдөв.

## 1961

ХАА-н нэгдлийн тариалангийн даатгал нэвтрүүлээ.

## 1934

Монгол Даатгал ХК-ийн суурь тавигдаж, анхны даатгалын үйл ажиллагааг эхлүүлэв.

## 1935

ЗХУ-ын Госстрах даатгалын газартай хамтран давхар даатгалын үйл ажиллагааг эхлүүлээ.

## 1936

“Албан байгууллага, аж ахуй нэгжийн даатгал” үйлчилгээг анх нэвтрүүлэв.

## 1946

Хувь хүн болон ажилтнуудад зориулсан амьдралын даатгалын бүтээгдэхүүн гаргав.

## 1947

“Тээврийн хариуцлагын заавал даатгал” хийж эхлэв.

## 1953

Зорчигчийн амь насны даатгал гаргав.

## 1949

Бөмбөгөр ногоон театрын хохирлыг барагдуулав



## 1959

Хоршооллын байгууллагын эд хөрөнгийн заавал даатгал нэвтрэв.


1949 он Бөмбөгөр ногоон театр нь Монгол Даатгал компанид даатгалтай байсан бөгөөд нийт 3 удаагийн гал гарч үүссэн хохирлыг тус тус нөхөн олгосон байна.



## ЭДИЙН ЗАСАГ

2022 онд Монгол Улсад цар тахлын нөхцөл байдал намжсан хэдий ч хил гаалийн асуудал үргэлжилсэнтэй холбоотой бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, инфляцын нөлөөгөөр иргэдийн худалдан авах чадвар буурсан, эдийн засаг, салбаруудын үйл ажиллагаа тасалдсан жил болж өнгөрлөө.

Монгол улсын эдийн засаг 2022 онд 4.8%-ийн өсөлттэй гарсан байна. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйн салбар 12%-иар /1.7 пункт/, бүтээгдэхүүний цэвэр татвар 11.5%-иар /1.4 пункт/, аж үйлдвэр, барилгын салбар 6.1%-иар /0.8 пункт/, үйлчилгээний салбар 5.5%-иар /2.6 пункт/ өссөн нь голлон нөлөөлсөн байна. Хил гаалийн хязгаарлалт, БНХАУ-ын цар тахлын нөхцөл байдлын улмаас уул уурхайн салбар 11.9%-иар буурч эдийн засгийн өсөлтөд -1.6 пунктийн сөрөг нөлөө үзүүлсэн байна.




### САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 24% Уул уурхай, олборлолт
- 13% Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур
- 11% Бүтээгдэхүүний цэвэр татвар
- 09% Бөөний, жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ
- 07% Боловсруулах үйлдвэрлэл
- 4.8% Санхүүгийн үйл ажиллагаа
- 04% Төрийн удирдлага ба батлан хамгаалах ү.а АЖНХ
- 04% Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа
- 04% Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа
- 04% Боловсрол
- 01% Барилга

## ДААТГАЛЫН САЛБАР

2022 оны байдлаар ердийн даатгагчдын нийт хөрөнгө 398.2 тэрбум төгрөг болж 12.3%-иар өссөн бол нийт хураамжийн орлого 297.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 23%-иар өссөн үзүүлэлттэй байна. Эдийн засгийн тогтворгүй байдал, инфляцын нөлөөгөөр даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ 37.6%-иар өсч 92.8 тэрбум төгрөг болсон нь даатгагчдын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Салбарын үзүүлэлт	2019	2020	2021	2022
Нийт актив	366	382	354.5	398.2
Өөрчлөлт %	45%	4%	-7%	12.3%
Нийт хураамжийн орлого	197	205	242.2	297.9
Өөрчлөлт %	12%	4%	18%	23%
Даатгалын гүнзгийрэлт, хувиар	0.53%	0.55%	0.56%	0.57%
Нөхөн төлбөр	64	55.8	67.4	92.8
Өөрчлөлт %	12%	-13%	21%	37.6%



Тайлант хугацаан дахь хохирлын харьцаа 54% байгаа болж өмнөх оноос 5 пунктээр өссөн бөгөөд зардлын харьцаа өнгөрсөн оны мөн үетэй адил түвшинд хадгалагджээ. Хохирлын харьцаа өсөхөд Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, автотээврийн хэрэгслийн даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ өссөнтэй холбоотой.

# САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баланс /сая төгрөгөөр/


БАЛАНС	2020Q4	2021Q4	2022Q4	Өөрчлөлт %
Эргэлтийн хөрөнгө	24,365	27,088	27,509	2%
Эргэлтийн бус хөрөнгө	10,540	9,959	9,974	0%
Үндсэн хөрөнгө	9,180	8,598	8,614	0%
<b>Нийт хөрөнгө</b>	<b>34,906</b>	<b>37,047</b>	<b>37,483</b>	<b>1%</b>
Нийт өр төлбөр	20,943	22,968	23,238	1%
Богино хугацаат өр төлбөр	2,519	1,866	4,781	156%
Нөөц сан	18,423	21,102	18,458	-13%
Эзэмшигчийн өмчийн дүн	13,963	14,078	14,245	1%
<b>Нийт өр төлбөр ба эзэмшигчийн өмч</b>	<b>34,906</b>	<b>37,047</b>	<b>37,483</b>	<b>1%</b>

Орлогын тайлан /сая төгрөгөөр/

ОРЛОГЫН ТАЙЛАН	2020Q4	2021Q4	2022Q4	Өөрчлөлт %
<b>Даатгалын хураамжийн нийт орлого</b>	<b>23,098</b>	<b>29,223</b>	<b>27,196</b>	<b>-7%</b>
Даатгалын хураамжийн цэвэр орлого	16,364	15,595	14,564	-7%
Нийт нөхөн төлбөрийн зардал	7,654	8,778	7,495	-15%
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	7,318	8,369	6,922	-17%
Хөрөнгө оруулалтын олз, гарз	1,166	3,001	358	-88%
Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)	8,973	8,111	9,712	20%
Үйл ажиллагааны зардал	8,719	8,187	9,619	17%
Бусад ашиг ( алдагдал)	(8,538.85)	(7,794.70)	(9,377.10)	20%
Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	434	316	335	6%
Орлогын албан татварын зардал	114	202	169	-17%
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>320</b>	<b>114</b>	<b>166</b>	<b>46%</b>

2022 онд компанийн нийт хөрөнгийн хэмжээ 37.4 тэрбум төгрөг, нөөц сангийн хэмжээ 18.4 тэрбум төгрөг болсон байна. Нийт хураамжийн орлого 7%-иар буурч 27.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд бид эрсдэлийн удирдлага, андеррайтингийн бодлогын хүрээнд гэрээний чанарыг сайжруулан, давхар даатгалд эрсдэлээ шилжүүлэн харилцагчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж 7.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагчдадаа олгож ажилласан байна.

Компанийн баримталж буй эрсдэлийн удирдлага, андеррайтингийн бодлоготой холбоотойгоор нийт хураамж, цэвэр хураамж бага хэмжээгээр буурсан хэдий ч хохирлын харьцаа салбарын дунджаас бага түвшинд хадгалагдсан байна.



# БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Манай компани байгуулагдсан цагаас хойш салбартаа шинэлэг шийдлийн нэвтрүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ тасралтгүй сайжруулж, харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн энгийн, хялбар ойлгомжтой байдлыг тэргүүнд тавьж харилцагч төвтэй бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхээр зорьж байна. Үүний дагуу компанийн бизнес хөгжил, борлуулалтын бодлого нь бүтээгдэхүүний чанар, зах зээлд өрсөлдөх чадвар болон даатгуулагчдад хүргэх борлуулалтын сувгийг үр ашигтайгаар шийдэхэд анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Бид Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй 14 хэлбэрийн, 76 даатгалын бүтээгдэхүүн борлуулан харилцагчдаа үйлчилж байна.

- Гэнэтийн осол эмчилгээний даатгал
- Хөрөнгийн даатгал
- Автотээврийн хэрэгслийн даатгал
- Ачаа тээврийн даатгал
- Барилга угсралтын даатгал
- Газар тариалангийн даатгал
- Мал амьтдын даатгал
- Агаар хөлгийн даатгал
- Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал
- Хариуцлагын даатгал
- Санхүүгийн даатгал
- Зээлийн даатгал
- Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал
- Албан журмын даатгал

## МОНГОЛ ДААТГАЛЫН ЦАХИМ ТУСЛАХ /CHATBOT/

- Даатгалын үйлчилгээ авах
- Даатгалын тохиолдлын зураг илгээх
- Нөхөн төлбөрийн явц шалгах
- Нөхөн төлбөрийн материал илгээх
- Гэрээ цуцлах хүсэлт илгээх
- Даатгалын бүхий л төрлийн зөвлөгөө авах
- Хаяг байршлын мэдээлэл харах



## ДАВХАР ДААТГАЛ

Бид хүлээн авсан эрсдэлээ үнэлэн, шинжилгээ хийж, өөрийн төлбөрийн чадвар, эдийн засгийн чадавх, макро эдийн засгийн өөрчлөлт, хандлагатай уялдуулан дэлхийн томоохон, нэр хүндтэй давхар даатгагч нарт эрсдэлийн багцаа Трити болон факультатив байдлаар нэг бүрчлэн давхар даатгуулдаг.

Бид давхар даатгагчдын санхүүгийн найдвартай байдлыг нэн түрүүнд чухалчлан, санхүүгийн хүчин чадлын үнэлгээгээр A.M.Best "A-", S&P "BBB"-ээс дээш үнэлгээтэй нэр хүнд бүхий зах зээлд тэргүүлэгч давхар даатгагчаар даатгуулдаг.

Манай факультатив давхар даатгалын эрсдэлийг Их Британи, Герман, Сингапур, Хон-Конг, Оросын холбооны улсад байрласан санхүүгийн хүчин чадлын зэрэглэл тогтоогч Standard & Poor's, A.M.Best, Fitch-ийн өндөр үнэлгээ бүхий давхар даатгалын компаниуд хүлээн авдаг.

Дэлхийд нэр хүндтэй, өндөр үнэлгээтэй, томоохон давхар даатгагч нар нь манай эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэхээс гадна, харилцагчдад хамгийн найдвартай, өндөр түвшний даатгалын хамгаалалт болон түргэн шуурхай үйлчилгээ авах боломжоор хангаж байгаа юм.

Давхар даатгах нөхцөлүүд:

- 5 сая ам.доллар хүртэлх үнэлгээтэй даатгалын гэрээнүүдийг багцын давхар даатгалын гэрээний дагуу автоматаар хамгаалалтад багтана.
- Багцын давхар даатгалын хамгаалалтаас давсан өндөр үнэлгээ бүхий эсвэл онцгой төрлийн үйл ажиллагаа явуулдаг харилцагчидтай факультатив давхар даатгалын гэрээг байгуулна.
- Олон улсын эрүүл мэнд, гадаад зорчигчдын гэнэтийн ослын даатгалын үйлчилгээг дэлхийн нэр хүндтэй, даатгалын зах зээлд тэргүүлэгч давхар даатгалын компаниуд Allianz Worldwide Care, Hannover Re, болон Ocean Re -тай хамтран харилцагч нартаа хүргэж байна.

Бид хүлээн авсан эрсдэл бүртээ шинжилгээ хийж шаардлагатай тохиолдолд давхар даатгалын хамгаалалтаар бүрэн хангаж харилцагчдынхаа найдвартай түнш байх зорилгоо тогтмол биелүүлсээр байна.

## ДАВХАР ДААТГАЛЫН ТҮНШҮҮД








Бид харилцагчдадаа эрсдэл тулгарсан, эрсдэлээс хамгаалах аль ч үед нь ойр байж боломжит харилцааны бүх сувгуудаар дамжуулан бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэхийг зорьж ажилладаг. 2022 онд лавлах утсанд нийт 90,750 дуудлага ирсэн байна.

Шуурхай алба, ослын дуудлага **60%**

Даатгал, бүтээгдэхүүнтэй холбоотой **23%**


Нөхөн төлбөрийн үйлчилгээтэй холбоотой **14%**

Санал хүсэлт **3%**




2022 онд нийт **9,174** даатгуулагчид **7.49** тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгожээ.

Нөхөн төлбөр авсан даатгуулагчдын тоо



Нөхөн төлбөрийн хэмжээ, сая төгрөгөөр



Нөхөн төлбөрийн бүтэц, бүтээгдэхүүнээр

	Нийт нөхөн төлбөр	Эзлэх хувь
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	485.80	6%
Хөрөнгийн даатгал	428.57	6%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	2,243.99	30%
Ачааны даатгал	14.68	0%
Барилга угсралтын даатгал	150.33	2%
Мал амьтдын даатгал	3.86	0%
Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	2.10	0%
Хариуцлагын даатгал	51.71	1%
Санхүүгийн даатгал	152.87	2%
Зээлийн даатгал	88.76	1%
Жолоочийн хариуцлагын даатгал	3,872.40	52%
Нийт	7,495.07	100%

Нийт нөхөн төлбөрийн 82%-ийг автомашинтай холбоотой даатгал эзэлж байгаа нь хураамжийн орлогын 50%-ийг тээврийн хэрэгслийн даатгал, жолоочийн хариуцлагын даатгал бүрдүүлдэг, даатгалын тохиолдлын тоо их байдагтай холбоотой.

## ДИЖИТАЛЧЛАЛ, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Бид бүтээгдэхүүн үйлчилгээгээ харилцагч, даатгуулагчдадаа энгийн хялбар шийдлээр хүргэхийн тулд цахим үйлчилгээний сувгуудаа хөгжүүлж ажиллаж байна.

“Монгол Даатгал” ХК-ийн аппликейшн, чатботоор дамжуулан иргэдийн даатгалын зах зээлд голчлон борлуулагддаг эрсдэлийн сонголтот тээврийн хэрэгслийн даатгал, гэнэтийн ослын даатгал, дотоод аяллын даатгалын бүтээгдэхүүнүүдийг авах боломжтой.

Мөн нөхөн төлбөрийн дугаараар нөхөн төлбөрийн процессийг хянах, даатгалын буцаалтын үйлчилгээг чатботоор авах боломжуудыг бүрдүүлж ажилласан.



### АВТОМАТЖУУЛАЛТ:

Даатгал буцаалт, нөхөн төлбөрийн процессийг сайжруулан бага дүн бүхий нөхөн төлбөрийн гүйлгээг автоматаар хийх боломжийг бүрдүүлсэн.



### ЛИЦЕНЗ:

Бид үйл ажиллагаандаа албан ёсны лиценз бүхий программ хангамжуудыг авч ашигладаг бөгөөд Windows 10 болон MS Office 365-ын албан ёсны лицензтэй.

## МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ:

Дижитал шилжилт, цахимжилтын эрин үед бид цаг үетэйгээ хөл нийлүүлэн технологийн шийдэл, цахим сувгуудыг нээж ажиллуулж байгаатай холбоотой харилцагчдын мэдээлэл, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах нь бидний нэн тэргүүний зорилт билээ.

Энэ хүрээнд бид цар тахлын нөхцөл байдалд ажилчдаа 100% зайнаас ажиллах боломжийг бүрдүүлж мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллаж дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Firewall дээр байгууллагын сүлжээнд нэвтрэх VPN сүлжээг тохируулж нийт ажилчдын 99% хувийг алсаас ажиллах нөхцөл боломжоор хангасан.
- Шуурхай төвийн утас IP based болсноор гэрээсээ шуурхай дуудлагыг хүлээж авах боломжтой болсон.
- Microsoft Office 365-ыг үргэлжлүүлэн ашигласнаар ажилчид зайнаас ажиллах, ажлын файлуудыг клоуд серверт аюулгүй хадгалах, онлайн хурал цуглааныг зохион байгуулах боломжуудыг бүрдүүлсэн.



## ХҮНИЙ НӨӨЦ

“Монгол Даатгал” ХК нь нийт 205 ажилтантай, 71% нь GEN Y болон GEN Z үеийн залуус бүрдүүлж байгаа бол жендерийн тэгш байдлыг хангах бодлогын хүрээнд нийт ажилтнуудын 63%-ийг эмэгтэй ажилтнууд бүрдүүлж байна. Насны бүлгийн хувьд бүх үеийн төлөөллүүд ажилладаг нь байгууллагын соёлын хувьд олон талт оролцоог эрхэмлэсэн арга хэлбэрүүдийг ашиглах зайлшгүй шаардлага тулгарч байдаг.

Мөн нийт ажилтнуудын 40% нь 5 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай ажилтнууд бүрдүүлдэг бөгөөд бид бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй хангахад шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлж, нийт 60 гаруй шинэ ажилтныг Монгол Даатгалын гэр бүлд нэгтгэлээ.

Мөн байршлын хувьд УБ хотод 60%, орон нутагт 40% нь байрладаг тул сургалтын болон зохион байгуулалтын олон арга хэлбэрүүдийг ашигладаг.

## Ажилтанд зориулсан хөгжил

Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг сайжруулахын тулд хүний нөөцийн сургалтын процесс тогтмол хийгдэж байна. 2022 онд ажилд орсон шинэ ажилтнуудад чиглүүлэх сургалт орохоос эхлээд мэргэжлийн ур чадварыг сайжруулахаар дотоод 30, гадаад 150 сургалтыг тус тус хийжээ.

Нэг ажилтанд ногдох сургалтын зардал: 344,400 төгрөг /сургалтын нийт зардлыг сургалтанд хамрагдсан ажилтны тоонд харьцуулсан харьцаа/ байна.





## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

“Монгол даатгал” ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын алба нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос /Хороо/ актуарын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ахлах актуарчтай бөгөөд гүйцэтгэх захирлын шууд удирдлагад ажиллаж байна. Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын албаны үндсэн гүйцэтгэх үүрэг, зорилго нь даатгагчийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэх бөгөөд даатгагчийн санхүүгийн байдал, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох аливаа эрсдэлээс зайлсхийх, бууруулах арга хэмжээг авч ажиллахдаа холбогдох хууль, хорооны журам болон компанийн бодлого, журамд нийцүүлэн ажилладаг.

2022 онд санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөх эрсдэл, андеррайтингийн үйл ажиллагааны эрсдэлд түлхүү анхаарал хандуулан зөвлөмж анхааруулга өгч ажилласан бөгөөд өмнөх жилд авч хэрэгжүүлж байсан ажлуудыг мөн үргэлжлүүлэн ажиллаж байна. Голчлон ажиллаж буй эрсдэлүүд ба тэдгээрийг бууруулж буй арга хэмжээнээс дурдвал:

### АНДЕРРАЙТИНГИЙН ЭРСДЭЛ

Андеррайтингийн эрсдэл нь дотроо даатгалын гэрээ нөхцөл, хураамжийн хувь, нөхөн төлбөр зэргийг багтаасан өргөн агуулгатай эрсдэл юм. Андеррайтингийн эрсдэлийг хяналтыг даатгалын гэрээ тус бүрийн хариуцлагын хэмжээнээс хамааран доорх бүтцээр баталдаг.

- Даатгалын гэрээний нийт үнэлгээ 1 тэрбум төгрөг хүртэлх бол Андеррайтингийн хороо хуралдаж шийдвэр гаргадаг. Андеррайтингийн хороо нь Гүйцэтгэх захирал, Андеррайтинг хариуцсан захирал, Байгууллагын даатгалын газрын захирал, давхар даатгалын мэргэжилтэн болон андеррайтингийн мэргэжилтэн гэсэн таван хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг.
- Даатгалын гэрээний нийт үнэлгээ 1 тэрбум төгрөгөөс дээш бол эхлээд Андеррайтингийн хороо хянаж ажиллах ба тухайн даатгалын гэрээг хийх боломжтой гэж үзсэн тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлөөр хянуулж эцсийн шийдвэрийг гаргадаг.

### НӨӨЦ САНГИЙН ЭРСДЭЛ

Даатгагч даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд Улирал бүр хорооны багц журмын гуравдугаар хавсралтын дагуу Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан, Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан, Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн тооцоолол хийж тайлан бэлтгэн хороонд хүргүүлдэг. Нөөц санг даатгуулагчдын эрх ашгийг хамгаалахуйц буюу хангалттай хэмжээнд байгуулан, тасралтгүй өсөн нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байна.

Өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлангийн хүрээнд байгууллагад учирч болзошгүй гол эрсдэлүүдийг тодорхойлж, эрсдэл тус бүрийг хэмжих харьцаа үзүүлэлтүүдийг сонгон эрсдэлийн аппетит болон эрсдэл хүлцэх чадваруудыг тодорхойлсон. Мөн эрсдэл бүр дээр эрсдэл даах хязгаараас давсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг боловсруулан тайланд тусгасан болно.



### “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөнд нэгдэв

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд “Монгол Даатгал” ХК-ийн хамт олон нэгдэж СХД-н 24-р хороонд 3 төрлийн 80 гаруй суулгацыг тарилаа.



### МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБОО

Монголын Эмэгтэйчүүдийн Холбооноос санаачлан хэрэгжүүлж буй умайн хүзүү болон хөхний хорт хавдрыг эрт илрүүлэх “ХАВДАРГҮЙ МОНГОЛ ЭМЭГТЭЙ” нийгмийн зорилтод төсөл Говь-Алтай аймгийн 9 суманд хэрэгжсэн билээ.

“Хавдаргүй монгол эмэгтэй” нийгмийн зорилтод төслийн багийн бүх гишүүдийн гэнэтийн ослын даатгал болон эмнэлгийн машинуудын бүх төрлийн даатгалыг “Монгол Даатгал” ХК хариуцан ажиллаж байна.

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Даатгалын бизнесийн мөн чанар нь нийгэмдээ чиглэсэн буюу аливаа эрсдэл учирсан үед тулгарч болох санхүүгийн эрсдэлээс хамгаалдаг боловч бид даатгалын боловсролыг багш сурган хүмүүжүүлэгчид, ирээдүйн бяцхан харилцагчдадаа олгох, мэдлэгийг нэмэгдүүлэх, одоо байгаа харилцагчдаа эрсдэлээс хамгаалах зорилгоор дараах хамтын ажиллагааг хэрэгжүүлэн нийгмийн хариуцлагаа биелүүлэн ажиллаа.



### ЦАХИМ СУВАРГА ТББ

Монгол орны мартагдсан өв соёлыг сэргээн хөгжүүлж дэлгэрүүлэх, нийтэд таниулан сурталчлах тулд техник технологид тулгуурлан, мэргэжлийн өндөр түвшинд баримтжуулан хадгалах зорилготой.



#promotingvolunteerism

### МОНГОЛЫН САЙН ДУРЫНХНЫ ТӨВ

Боловсролын чиглэлээр ажиллах сайн дурын залуучуудын оролцоотойгоор захын дүүргийн зорилтод ерөнхий боловсролын сургуулийн 5-7 ангид суралцаж буй хүүхдүүдийн англи хэл, монгол хэл, математикийн хичээлийн хоцрогдлыг арилгахад тогтвортой дэмжлэг үзүүллээ.

# ЯАГААД МОНГОЛ ДААТГАЛ ГЭЖ

## САЛБАРЫН ТЭРГҮҮЛЭГЧ



89 жилийн түүхтэй "Монгол Даатгал" ХК нь салбарын анхдагч компани, ололт амжилтуудыг бүтээж ажиллагдийн хувьд өөрийн өргөн мэдээлэл, технологийн дэвшлүүдийг ашиглан харилцагчдынхаа эрсдэлд бодитой үнэлэлт өгөх туршлагатай байж хэрэглэгчдийн тэргүүн сонголт байсаар ирлээ.

## МЭРГЭШСЭН БАГ



Харилцагчдынхаа эрсдэлийг бодитой үнэлэхийн тулд ажилтнуудын мэргэшил, ур чадварыг чухалчлан тогтмол сургалтад хамруулж мэргэжлийн, мэргэшсэн баг бүрдүүлэн ажиллаж байна.

## ДААТГАЛЫН ӨРГӨН СҮЛЖЭЭ



Монгол улсын 21 аймаг, нийслэл хотын дүүрэг бүрд байрласан 25 салбар нэгж, 700 гаруй мэргэшсэн даатгалын төлөөлөгч бүхий даатгалын борлуулалтын хамгийн өргөн сүлжээгээр дамжуулан харилцагчдадаа үйлчилдэг.

## БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ



Даатгалын зах зээлд ёс суртахууны өндөр хэм хэмжээнд мэргэжлийн төвшинд эрсдэлийн удирдлагын зөвлөгч байж, олон улсын жишигт хүрсэн үйлчилгээг үзүүлэн, тэдний санхүүгийн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэн ажиллаж, гэрээгээр хүлээсэн үүргээ нэр төртэйгөөр биелүүлэн ажиллаж байна.

## ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ТЭРГҮҮЛЭГЧ



Бид харилцагчийнхаа санал хүсэлтийг 7/24 цагаар хүлээн авч шуурхай шийдвэрлэн, эрсдэлийн төрөл бүрийн сургалт зөвлөгөө өгөх зэргээр харилцагчдыг эрсдэлээс хамгаалахад бүх талаар анхаарал хандуулан тэдний сэтгэл ханамжийг эрхэмлэж ажилладаг.

## НӨХӨН ТӨЛБӨРИЙН БОДИТ БАТАЛГААЖУУЛАЛТ



Эрсдэлийг цаг хугацаа алдалгүй баталгаажуулахыг эрхэм зорилго болгож салбартаа хамгийн өргөн бүрэлдэхүүнтэй мэргэшсэн шуурхай албыг 7/24 цагийн туршид Улаанбаатар хот болон орон нутаг даяар ажиллаж байна.

# ХАРИЛЦАГЧДЫН ТӨЛӨӨЛӨЛ

**APU COMPANY**  
Absolute. Pure. Unique.





